



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/24

Хараат

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/218 дугаар захирамжийг үндсэлэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн ургамал сүйтгэгч үлийн цагаан оготнотой микробилогийг аргаар тэмцэх ажлыг орон нутагт зохион байгуулж байгаатай холбогдуулан хавсралтад заасан бэлчээрийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 5 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл чөлөөлсүгэй.
2. Бэлдмэл цацаж, тэмцэх ажил зохион байгуулан талбайгаас мал сүргээ эрүүл нутаг, бэлчээрт гарган чөлөөлөхийг малчдад үүрэг болгосугай.
3. Бэлчээр чөлөөлөх хугацаанд хөдөлмөр хамгаалал, хүн, малын эрүүл ахуйн шаардлагыг хангах талаарх мэдээллийг малчдад хүргэж, зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

